



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/204

Номгон


Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
хяналтыг сайжруулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “в”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 133 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”, аймгийн Засаг даргын 2020 оны А/02, аймгийн Онцгой комиссын 2021 оны 27 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Коронавирус (COVID-19)-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлж, халдварын голомтын бүсээс ирсэн иргэдийг хянах хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор “CLIX GPS” хяналтын системийг аймгийн хэмжээнд ашиглах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Тагнуулын хэлтсийн дарга, аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын Тандалт, ажиглалт, хяналтын багийн ахлагч (дэд хурандаа Р.Мэндбаяр)-д үүрэг болгож, зардлыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх ажлыг зохион байгуулахтай холбогдон гарах зардалд шаардагдах 9.400.000 (Есөн сая дөрвөн зуун мянган) төгрөгийг аймгийн Онцгой комиссын Дотоодын хандив, тусламжийн сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Онцгой комиссын Дотоодын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, хуваарилах ажлын хэсгийн дарга (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар
сарын 24-ний өдрийн А/204 дүгээр захирамжийн
хавсралт



ИРГЭДИЙН ГЭРИЙН ХЯНАЛТЫН "CLIX GPS"
СИСТЕМИЙГ АШИГЛАХАД ШААРДАГДАХ
ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын нэр	Нэг бүрийн үнэ	тоо	Мөнгөн дүн
1	Процесор	1.800.000	2	3.600.000
2	Нетбүүк	1.600.000	1	1.600.000
3	Дэлгэц	1.600.000	1	1.600.000
4	Интернет антенн Мобиком	2.600.000	1	2.600.000
5	Нийт			9.400.000

оОо